

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 5 ДУГААР САРЫН 1 ДЭХ
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

№ 15

2018.05.03

Өлгий сум

Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.

Тус Цагдаагийн газар өнгөрсөн 7 хоногийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 64 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд 5 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн.

Мөн 17 гомдол, мэдээлэлд хэрэг нээхээс татгалзсан.

Хулгайлах хэрэг 2, хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг 1, бусад төрлийн 2 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Нийт 209 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 189 хүнд 8.110.000 төгрөгийн тогуулийн шийтгэл оногдуулсан, 7 хүн баривчлагдсан, 20 хүн эрүүлжүүлэгдсэн.

Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.

1. “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” дэлхийн өдрийг угтаж аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг аймгийн төв талбайд 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

Уг арга хэмжээний хүрээнд аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Хүүхдэд тулгамдаж байгаа асуудал, шийдэл” сэдэвт гар зургийн уралдаан явуулж, дүгнэсэн бөгөөд хүчирхийллийн эсрэг хүүхдийн дуу хоолойг олон нийтэд хүргэх, хүүхэд, багачуул, иргэдэд хууль тогтоомж сурталчилж, хуулийн зөвлөгөө, мэдээ мэдээлэл өгөх ажлыг хэрэгжүүлэн ажиллав.

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор нийт 300 гаруй хүнд сургалт зохион байгуулав.

3. 2018 оны эхний 4 сарын хугацаанд 376 хүн эрүүлжүүлэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 195 хүнээр, баривчлагдсан хүн 23 хүнээр тус тус нэмэгдсэн нь архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

4. Хүүхэд оролцсон 11 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 66.6 хувиар өссөн байна.

5. Аймгийн хэмжээнд архины хамааралтай нийт 66 хүн бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 16 хүнийг эмчийн үзлэгт хамруулж, дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗАР